

“АРИГ ГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Ариг гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн 17.00 цагт компанийн хурлын танхимд болно.Хурлаар


1. “Ариг гал” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны талаарх гүйцэтгэх захирлын тайланг сонсох,компанийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. ТУЗ-ийн хараат болон энгийн гишүүдийг сонгох
- 3 Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг батлах
4. Компанийн удирдлагын зардлыг батлах асуудлыг хэлэлцэнэ.

Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрөөр, саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 12.00 цагаар тасалбар болгоно. Хурлын даргаар Д.Мөнхбат, хурлын тооллогын комиссын даргаар Д.Мөнхбаатар ажиллана.

Жич:Хурлыг материалтай харъяа брокерын контор дээрээс болон “Ариг гал” ХК-ийн веб сайтаас танилцана уу.

Утас: 11-343613, 99113825, 91914199

Хурал зохион байгуулах комисс



“ АРИГ ГАЛ “
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03 дугаар
сарын 18- ны өдөр

Дугаар 14 /21

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын “Компанийн тухай хууль”- ийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дахь заалт Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, түүнд СЗХ-ны 2021 оны 45 тоот тогтоолоор оруулсан нэмэлт өөрчлөлтийн холбогдох заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1.“Ариг гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04-р сарын 29-ны өдрийн 17 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 19-р хороо, Үйлдвэрийн парк-1 хаягт байрлах компанийн байр. Хурлын танхимд хуралдуулсугай.

2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурьдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:

2.1 Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн үр дүнгийн талаарх гүйцэтгэх захирлын тайланг сонсох ;

2.2 Компанийн 2021 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

2.3. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;

2.4. 2021 оны үйл ажиллагааны үр дүнгээр хуваарилах ногдол ашгийн хувь хэмжээг тогтоосон ТУЗ-ийн хурлын 2022 оны 2 сарын 18-ны өдрийн 12.21 тоот шийдвэрийг хэлэлцэж батламжлах.

2.5 Компанийн удирдлагын 2022 оны зардлын төсвийг хэлэлцэж батлах

3.Хурал хуралдуулах тухай мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо МХБ-д мэдэгдэх өдрийг 2022 оны 3 дугаар сарын 22-ны өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр зарлах өдрийг 2022 оны 3 дугаар сарын 22 болон 4 дүгээр сарын 08-ний өдрүүдээр тогтоосугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрөөр тогтоосугай.

5.Хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокерийн компанид хурлын материалыг 2022 оны 3 сарын 29 дотор хүргүүлэх, эхний болон давтан зарыг өдөр тутам хэвлэгдэн гардаг 2-оос доошгүй сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэн, хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг Хурал зохион байгуулах комисс (Д.Мөнхбат)-т даалгасугай.

6. Дараах бичиг баримтуудыг компанийн байр болон хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокер диллерийн компаниуд дээр бэлэн байлгах, Имайлаар хүргүүлэн, хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдахаас өмнө танилцуулах ажлыг зохион байгуулахыг, Хурал зохион байгуулах комисс (Д.Мөнхбат)-т үүрэг болгосугай.

Үүнд:

- 6.1.Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоолын хуулбар;
- 6.2.Хурлаар хэлэлцэх асуудлуудаар гарах шийдвэрийн үндэслэл болох үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлан,компанийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлт;
- 6.3. Хурлын санал хураах хуудасны загвар.
- 6.4. ТУЗ-ийн энгийн болон хараат бус гишүүдийн тухай танилцуулга, Нэр дэвшүүлэх хорооны тогтоол
- 6.5. Компанийн удирдлагын зардлын 2022 оны зардлын төсөв
- 6.6 Ххувьцаа эзэмшигчдэд 2021 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахаар шийдвэр гаргасан тухай ТУЗ-ийн 12/21 тоот тогтоол
- 6.7 Хурлаас гаргах шийдвэрийн тогтоолын төслүүд
7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал хураах хуудасны загварыг энэхүү шийдвэрийн Хавсралт
№1-ээр баталсугай.
8. Санал хураах хуудсыг хүлээн авах сүүлчийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 12 цагаар тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар ТУЗ-ийн гишүүн Д.Мөнхбатыг, хурлын тооллогын комиссын даргаар Д.Мөнхбаатарыг томилсугай.
10. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга материал, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг, хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комисс /Д.Мөнхбат/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

С.МӨНХЖАРГАЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН

Б.БОЛД
Б.АЮУШ
Б.ЁНДОНЖАМЦ
Э.БЯМБАЖАВ
Д.ГИВААПИЛ
С.АЛИМАА
Д.МӨНХБАТ